



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/163

Арвайхээр

Г Журам батлах тухай 1

Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4.3, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь заалт, 2022 оны Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 08 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаартай "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам" тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаартай "Журам батлах тухай /Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах/" тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр "Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийг журам бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай" тушаал, Монгол Улсын "Өвчний түүх бичих стандарт MNS 4621:2006 стандарт"-г тус тус үндэслэн тушаах нь:

1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөр үйлчлүүлэгчдийн өвчний түүх бичих журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Өвчний түүх бичих журмыг 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс хэрэгжүүлэн сургалт арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга (Ц.Лувсандамдин) тасгийн эрхлэгч, сувилахуйн арга зүйч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвөлгөө өгч ажиллахыг Эмнэлзүйн эрсдэл хариуцсан Чанарын менежер (Л.Золзаяа), Чанарын менежер (Ж.Нарантуяа), Эрүүл мэндийн даатгалын эмч (О.Батболд) нарт тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ  Г.ДАШЖАНЦАН

